НЬЮБАЛАНС АУДИТ

Аудит, Нягтлан бодох бүртгэл, Зөвлөх үйлчилгээ

АУДИТЫН ТАЙЛАН

“ ПИ ЭФ ЭЛ ” ББСБ-ИЙН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТУХАЙД

2023 он

НЬЮБАЛАНС АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ ПИ ЭФ ЭЛ ” ББСБ-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид “ПИ ЭФ ЭЛ” ББСБ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн Байдлын Тайлан, Орлогын Дэлгэрэнгүй Тайлан, Өмчийн Өөрчлөлтийн Тайлан, Мөнгөн Гүйлгээний Тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, бусад тайлбар тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг талаараа “ПИ ЭФ ЭЛ” ББСБ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу, Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ууд болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомжуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн Удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 29-ний хурлаар баталсан Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Олон улсын нягтлан бодогчдын холбооноос гаргасан “*Нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм*”-ийн 290-р бүлэг *“Аудит болон нягтлах ажлын хараат бус байдал*” болон 291 дүгээр бүлэг “*Бусад баталгаажуулах ажлын хараат бус байдал*”-д шаардсан ёс зүйн шаардлагуудыг мөрдсөн болно.

Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-уудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо
Ялалт плаза 8 давхар 805 тоот
Утас: 99101901, 89110525, 89110535
Факс: (976)-70145542
Вэб сайт: www.newbalance-audit.com
И-мейл: newbalance.auditllc@gmail.com

НЬЮБАЛАНС АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК

Гүйцэтгэх захирал

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК
NEWBALANCE AUDIT
ТТБ5097 5098696

Б.Лхагвадорж №:22/01/100

2023 оны 04 дүгээр сарын 03 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо
Ялалт плаза 8 давхар 805 тоот
Утас: 99101901, 89110525, 89110535
Факс: (976)-70145542
Вэб сайт: www.newbalance-audit.com
И-мейл: newbalance.auditllc@gmail.com

"'ПИ ЭФ ЭЛ " ББСБ

Аудитын дүгнэлтийн хавсралт:
(хураангуй)

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 оны 04-р улирал

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	
		Аудитлагдаагүй	Аудитлагдсан
А. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
Эргэлтийн хөрөнгийн дүн		2,809,039.88	2,809,039.88
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		48,391.88	48,391.88
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**2,857,431.76**	**2,857,431.76**
Өр төлбөрийн нийт дүн		26,634.75	26,634.75
Эздийн өмчийн дүн		2,830,797.01	2,830,797.01
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		**2,857,431.76**	**2,857,431.76**
Б. ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
1	Хүүгийн орлого	151,527.17	151,527.17
2	Хүүгийн зардал	-	-
Цэвэр хүүгийн орлого		**151,527.17**	**151,527.17**
3	Хүүгийн бус орлого	596,472.09	596,472.09
4	Хүүгийн бус зардал	481,651.71	481,651.71
Цэвэр хүүгийн бус орлого /зардал/-ын дүн		**114,820.38**	**114,820.38**
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг /алдагдал		**266,347.55**	**266,347.55**
5	Болзошгүй эрсдлийн сан	-	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/		**266,347.55**	**266,347.55**
6	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-
7	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/		**266,347.55**	**266,347.55**
8	Ердийн бус орлого	-	-
9	Ердийн бус зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал (12+13-14)		**266,347.55**	**266,347.55**
10	Орлогын татварын зардал	26,634.75	26,634.75
ЦЭВЭР АШИГ		**239,712.79**	**239,712.79**
В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН			
1	**Хувьцаат капиталын эхний үлдэгдэл**	**2,500,000.00**	**2,500,000.00**
2	Нэмэгдсэн өөрчлөлт	-	-
3	Хасагдсан өөрчлөлт	-	-
4	**Хувьцаат капиталын эцсий үлдэгдэл**	**2,500,000.00**	**2,500,000.00**
5	**Хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл**	**91,084.21**	**91,084.21**
6	Тайлант үеийн ашиг /алдагдал/	239,712.79	239,712.79
7	Ногдол ашиг	-	-
8	**Хуримтлагдсан ашгийн эцсийн үлдэгдэл**	**330,797.01**	**330,797.01**
9	**Эзэмшигчдийн өмчийн дүн**	**2,830,797.01**	**2,830,797.01**
Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**413,677.51**	**413,677.51**
1.1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	747,999.26	747,999.26
1.2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	(334,321.75)	(334,321.75)
2	**Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**(1,614.41)**	**(1,614.41)**
2.1	Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	0.00	0.00
2.2	Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	(1,614.41)	(1,614.41)
3	**БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**412,063.10**	**412,063.10**
4	**МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ**	**64,490.49**	**64,490.49**
5	**МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ**	**476,553.59**	**476,553.59**

АУДИТОР Л.НАРАНБААТАР

НЬЮБАЛАНС-АУДИТ ХХК
АУДИТЛАВ
5098696